



## **Иргэний нисэхийн аюулгүй байдлын анхан шатны сургалт**

### **1. Сургалтын зорилго:**

Нисэхийн аюулгүй байдлыг хангахад тавигдах шаардлагууд, эрх зүйн баримт бичгүүд, аюулгүй хамгаалалтын эрх үүрэг хариуцлага, иргэний нисэхийг хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалах цогц арга хэмжээ, агаарын хөлгөөр тээвэрлэхийг хориглосон эд зүйлс, түүнийг таньж илрүүлэх, аюулгүйн үзлэг шалгалт хийх арга аргачлал, тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тавьсан талаарх мэдээлэл хүлээн авах, дамжуулах болзошгүй эрсдэл болон заналхийллийн үед ажиллах, онцгой нөхцөл байдлын үед авах арга хэмжээний талаар анхан шатны мэдлэг олгох.

### **2. Суралцагчдад тавигдах шаардлага:**

Бүрэн дунд болон түүнээс дээш боловсролтой байх,

### **3. Сургалтын агуулга:**

- ИНАБ-ын эрх зүйн баримт бичгүүдийг судлах,
- Иргэний нисэхийн эсрэг хөндлөнгийн хууль бус үйлдэл, заналхийллийн талаар мэдэх,
- НБ-ын бүсүүдэд нэвтрэх,
- Аюулгүйн үзлэг шалгалт хийх
- Тоног төхөөрөмж ашиглах

### **4. Сургалтын орчин /танхим цахим/:**

Танхим

### **5. Сургалт зохион байгуулагдах хугацаа:**

98 цаг буюу 13 өдөр

### **6. Анги дүүргэлт:**

15-20 суралцагч байна.

-----o0o-----o0o-----o0o-----



## **Иргэний нисэхийн аюулгүй байдлын ажилтны давтан сургалт**

### **1. Сургалтын зорилго:**

ИН-ийн аюулгүй байдлын үзлэгийн шалгагчийг иргэний нисэхийн салбарт гарч буй өөрчлөлт шинэчлэлтийн хүрээнд аюулгүй байдлын үзлэгийн технологи, арга аргачлал, тоног төхөөрөмжийн ашиглалт болон холбогдох баримт бичигт орсон өөрчлөлтүүдтэй танилцаж, ажлын байранд ашиглах мэдлэг ур чадвар дадлыг бататган сэргээхэд оршино.

### **2. Суралцагчдад тавигдах шаардлага:**

- Иргэний нисэхийн аюулгүй байдлын анхан шатны сургалтад хамрагдсан байх
- Аюулгүй байдлын үзлэгийг бие даан гүйцэтгэх чадвартай болсон байх

### **3. Сургалтын агуулга:**

- Эрх зүйн баримт бичгүүдтэй танилцах,
- Нисэх буудлын аюулгүйн хамгаалалт
- Тоног төхөөрөмжийг ашиглах

### **4. Сургалтын орчин /танхим цахим/:**

Танхим

### **5. Сургалт зохион байгуулагдах хугацаа:**

40 цаг буюу 5 өдөр

### **6. Анги дүүргэлт:**

15-20 суралцагч байна.

-----o0o-----o0o-----o0o-----



## **Нисэхийн аюулгүй байдлын чанарын хяналтын мэдлэг олгох сургалт**

### **1. Сургалтын зорилго:**

Нисэхийн аюулгүй байдлын чанарын хяналт хариуцсан ажилтан нь аюулгүй байдлын дотоод хяналтыг хэрэгжүүлэх чадвар, дадал болон онолын мэдлэг эзэмших болно.

### **2. Суралцагчдад тавигдах шаардлага:**

Аюулгүй байдлын үзлэгийн удирдах албан тушаалд 2-оос доошгүй жил ажилласан эсхүл Аюулгүй байдлын дотоод чанар баталгаажуулалтыг гүйцэтгэх чиг үүрэг бүхий албан тушаалтан байх.

### **3. Сургалтын агуулга:**

- Нисэхийн аюулгүй байдлын чанарын хяналтын ерөнхий ойлголт
- Аюулгүй байдлын чанарын хяналт
- Аюулгүй байдлын аудитын үйл явц
- Аюулгүй байдлын судалгаа
- Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо /Security Management System/

### **4. Сургалтын орчин /танхим цахим/:**

Танхим болон цахим

### **5. Сургалт зохион байгуулагдах хугацаа:**

32 цаг буюу 4 өдөр

### **6. Анги дүүргэлт:**

15-аас ихгүй байна.

-----o0o-----o0o-----o0o-----



## **Аюултай барааны сургалт**

### **1. Сургалтын зорилго:**

Зорчигч болон нисэх багийн гишүүдийн тээш, ачаанд аюулгүйн үзлэг хийх аюулгүй байдлын ажилтнуудыг IATA Аюултай барааны дүрмийн дагуу зайлшгүй мэдэх шаардлагатай сэдвүүдийн дагуу онолын мэдлэг олгож, аюултай барааг зөв таних, аюултай барааны хязгаарлалт, аюултай барааг нуугдмал хэлбэрээр агаарын хөлөгт ачигдахаас урьдчилан сэргийлэх болон аюултай бараатай холбоотой осол зөрчлийн үед анхан шатны арга хэмжээ авах тухай мэдлэг олгоход оршино.

### **2. Суралцагчдад тавигдах шаардлага:**

-

### **3. Сургалтын агуулга:**

- Аюултай барааны суурь ойлголтыг ойлгох
- Ачаа тээш хүлээн авах
- Аюулгүй ажиллагааны мэдээлэл цуглуулах

### **4. Сургалтын орчин /танхим цахим/:**

Танхим/цахим

### **5. Сургалт зохион байгуулагдах хугацаа:**

14 цаг буюу 2 өдөр

### **6. Анги дүүргэлт:**

15-20 суралцагч байна.

-----oOo-----oOo-----oOo-----



## **Нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагыг нисэхийн мэдээлэл, нисэхийн өгөгдлөөр хангах томилогдсон мэдээлэгчийн сургалт**

### **1. Сургалтын зорилго:**

Иргэний нисэхийн багу дүрмүүд, нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагыг нисэхийн мэдээлэл, нисэхийн өгөгдлөөр хангах ерөнхий журам, хамтын ажиллагааг зохицуулах журам, хамтран ажиллах гэрээний дагуу нисэхийн мэдээлэл нисэхийн өгөгдлийг бэлтгэх, дамжуулах, мэдлэг, ур чадвар, хандлагыг эзэмшүүлэх

### **2. Суралцагчдад тавигдах шаардлага:**

Нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагыг нисэхийн мэдээлэл нисэхийн өгөгдлөөр хангахаар томилогдсон мэдээлэгч байна.

### **3. Сургалтын агуулга:**

- Нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагад дамжуулах нисэхийн мэдээлэл болон нисэхийн өгөгдлийг бэлтгэх
- Нисэхийн мэдээлэл болон нисэхийн өгөгдлийг нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагад дамжуулах
- Бүтээгдэхүүний төсөлд зөвшөөрөл олгох

### **4. Сургалтын орчин /танхим цахим/:**

Цахим/танхим

### **5. Сургалт зохион байгуулагдах хугацаа:**

26 цаг буюу 3 өдөр

### **6. Анги дүүргэлт:**

15-20 суралцагч байна.

-----oOo-----oOo-----oOo-----



## **Нисэхийн мэдээллийн үйлчилгээний анхан шатны сургалт**

### **1. Сургалтын зорилго:**

Нисэхийн мэдээллийн үйлчилгээний чиглэлээр ажиллах хүний нөөцийг бэлтгэх, суралцагчдад НМҮ-нд шаардлагатай анхан шатны мэдлэгийг олгоход энэхүү сургалтын зорилго оршино.

### **2. Суралцагчдад тавигдах шаардлага:**

-

### **3. Сургалтын агуулга:**

- Эрх зүйн баримт бичгүүдтэй танилцах
- Нислэгийн үндсэн онолын талаарх мэдлэг олгох
- Нислэгийн үйл ажиллагаанд оролцогч байгууллагуудын үйлчилгээг судлах, танилцах
- Нисэхийн мэдээллийн үйлчилгээний талаарх мэдлэг олгох

### **4. Сургалтын орчин /танхим цахим/:**

Танхим

### **5. Сургалт зохион байгуулагдах хугацаа:**

240 цаг буюу 30 өдөр

### **6. Анги дүүргэлт:**

5-15 суралцагч

-----o0o-----o0o-----o0o-----



## **Аэродромын хөдөлгөөнт бүсэд тээврийн хэрэгслээр хөдөлгөөн үйлдэх анхан шатны сургалт**

### **1. Сургалтын зорилго:**

Аэродромын маневрлах талбай болон перрон дээр тээврийн хэрэгслээр технологийн дагуу хөдөлгөөн үйлдэх, аюулгүй ажиллагааны мэдлэг олгох, богино долгионы радио станц ашиглах, агаарын хөлөгт хөндлөнгийн хүчин зүйлсээс үүсч болзошгүй осол, зөрчил аюулаас урьдчилан сэргийлэх мэдлэг чадвар эзэмших

### **2. Суралцагчдад тавигдах шаардлага:**

МУ-ын жолооны үнэмлэхтэй байх,

### **3. Сургалтын агуулга:**

- Эрх зүйн баримт бичгүүдтэй танилцах
- Газрын үйлчилгээний тусгай тоноглолтой автомашин механизм, тоног төхөөрөмжүүдийг ашиглах
- Хөөрч буух зурвас явгалах зам, перрон талбайд тээврийн хэрэгслээр хөдөлгөөн үйлдэх
- Агаарын хөлгийн зогсоолд тээврийн хэрэгслээр хөдөлгөөн үйлдэх
- Гэнэтийн үед авах арга хэмжээ, урьдчилан сэргийлэх

### **4. Сургалтын орчин /танхим цахим/:**

Танхим

### **5. Сургалт зохион байгуулагдах хугацаа:**

38 цаг буюу 5 өдөр

### **6. Анги дүүргэлт:**

15-20 суралцагч байна.

-----oOo-----oOo-----oOo-----



## **Аэродромын хөдөлгөөнт бүсэд тээврийн хэрэгслээр хөдөлгөөн үйлдэх давтан сургалт**

### **1. Сургалтын зорилго:**

Аэродромын хөдөлгөөнт бүсэд тээврийн хэрэгслээр технологийн дагуу хөдөлгөөн үйлдэх аюулгүй ажиллагааны аюулгүй ажиллагааны мэдлэг болон богино долгионы радио станц ашиглах, агаарын хөлөгт хөндлөнгийн хүчин зүйлсээс үүсэж болзошгүй зөрчил болон аюулаас урьдчилан сэргийлэх мэдлэг, чадварыг бататган сэргээх.

### **2. Суралцагчдад тавигдах шаардлага:**

- МУ-ын жолооны үнэмлэхтэй байх,
- Аэродромын хөдөлгөөнт бүсэд тээврийн хэрэгслээр хөдөлгөөн үйлдэх анхан шатны сургалтад хамрагдсан байх

### **3. Сургалтын агуулга:**

- Эрх зүйн баримт бичгүүдтэй танилцах
- Газрын үйлчилгээний тусгай тоноглолтой автомашин, механизм, төхөөрөмжүүдийг ашиглах
- Хөөрч буух зурвас, явгалах зам, перрон талбайд тээврийн хэрэгслээр хөдөлгөөн үйлдэх
- Агаарын хөлгийн зогсоолд тээврийн хэрэгслээр хөдөлгөөн үйлдэх

### **4. Сургалтын орчин /танхим цахим/:**

Танхим

### **5. Сургалт зохион байгуулагдах хугацаа:**

16 цаг буюу 2 өдөр

### **6. Анги дүүргэлт:**

15-20 суралцагч байна.

-----o0o-----o0o-----o0o-----





## **Газарт агаарын хөлгийн мөстөлтийг арилгах, мөстөлтөөс хамгаалах ажилтны сургалт**

### **1. Сургалтын зорилго:**

Суралцагч нь агаарын хөлгийн бүтэц зохион байгуулалт, мөстөлтийг арилгах, мөстөлтөөс хамгаалах шингэний шинж чанар, ашиглалт, аюулгүй ажиллагаа болон шингэн шүрших технологийн үйл ажиллагаа, агаарын хөлөгт мөстөлтөөс үүсч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх мэдлэг чадварыг олгох

### **2. Суралцагчдад тавигдах шаардлага:**

- Оператор инженер нь: МУ-ын жолооны үнэмлэхтэй байх, техникийн чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн байх
- Оператор жолооч нь: МУ-ын жолооны үнэмлэхтэй, жолооны ангилал В, С болон түүнээс доошгүй байх
- Аэродромын хөдөлгөөнт бүсэд тээврийн хэрэгслээр хөдөлгөөн үйлдэх жолооч операторчны анхан шатны сургалтад хамрагдаж гэрчилгээжсэн байх
- ICAO Annex 1-д нийцсэн эрүүл мэндийн шаардлага хангахын зэрэгцээ энэхүү сургалтад 1 жил тутамд хамрагдана.

### **3. Сургалтын агуулга:**

- Агаарын хөлгийн мөстөлтийг арилгах, мөстөлтөөс хамгаалах арга хэмжээтэй холбогдох олон улсын хууль, дүрэм, стандартууд
- Газарт агаарын хөлгийн мөстөлтийг арилгах, мөстөлтөөс хамгаалах шаардлага
- Агаарын хөлөгт мөстөлтийн эсрэг шингэн хэрэглэх дадлага аргачлалууд
- Агаарын хөлгийн мөстөлтийг арилгах, мөстөлтөөс хамгаалах үйл ажиллагаануудын онцлого асуудлууд
- Агаарын хөлгийн мөстөлтийг арилгах, мөстөлтөөс хамгаалах үйл ажиллагааны харилцаа холбоо
- SAFEAERO үйлдвэрийн TYRHOON загварын автомашин, тусгай тоноглол
- Агаарын хөлгийн үйлчилгээний бүсэд жолооч-операторчин нарт ажлын дадлага олгох

### **4. Сургалтын орчин /танхим цахим/:**

Танхим

### **5. Сургалт зохион байгуулагдах хугацаа:**

80 цаг буюу 10 өдөр

### **6. Анги дүүргэлт:**

12-18 суралцагч байна.



## **Агаарын хөлөг-газрын үйлчилгээний техникчдийн давтан сургалт**

### **1. Сургалтын зорилго:**

Нисэх буудалд нислэг үйлдэдэг буй агаарын хөлөгт үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай эрх зүйн баримт бичиг, дүрэм журмыг сэргээн санах, газрын үйлчилгээ үзүүлэхэд аюулгүй ажиллагааг хангаж ажиллах ур чадварыг дээшлүүлэх.

### **2. Суралцагчдад тавигдах шаардлага:**

Агаарын хөлөг-газрын үйлчилгээний техникчдийн суурь сургалтад хамрагдсан байх

### **3. Сургалтын агуулга:**

- Эрх зүйн баримтыг сэргээх
- Агаарын хөлгийн аюулгүй ажиллагааг хангах

### **4. Сургалтын орчин /танхим цахим/:**

Танхим

### **5. Сургалт зохион байгуулагдах хугацаа:**

18 цаг буюу 2 өдөр

### **6. Анги дүүргэлт:**

15-20 суралцагч байна.



## **Орон нутгийн нисэх буудлын шатахууны нярав лаборантын давтан сургалт**

### **1. Сургалтын зорилго:**

Нислэгийн аюулгүй ажиллагааг хангах зорилгоор агаарын хөлгийн шатахууныг хүлээн авах, хадгалах, түгээх үеийн технологи, үйл ажиллагааг MNS4633 стандартын дагуу гүйцэтгэх, хүлээн авах, түгээх үеийн шинжилгээ хийх чадварыг эзэмших.

### **2. Суралцагчдад тавигдах шаардлага:**

Нярав лаборантын мэргэжлийн үнэмлэхтэй байх

### **3. Сургалтын агуулга:**

- Шатахуун технологи үйл ажиллагааг гүйцэтгэх
- Агаарын хөлгийн шатахуунд хадгалах түгээх үеийн шинжилгээ хийх
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм журмыг мөрдөн ажиллах

### **4. Сургалтын орчин /танхим цахим/:**

Цахим/ танхим

### **5. Сургалт зохион байгуулагдах хугацаа:**

40 цаг буюу 5 өдөр

### **6. Анги дүүргэлт:**

15-20 суралцагч байна.



## **Аэродромын үйл ажиллагааны сургалт**

### **1. Сургалтын зорилго:**

Аэродромын үйл ажиллагааг хариуцаж буй инженер, техникийн болон нисэх буудлын үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд оролцдог бусад ажилтнууд, нисэх буудлын удирдлагад иргэний нисэхийн аэродромын аюулгүй ажиллагаа, үйлдвэрлэлийн зохион байгуулалт, эрх зүйн орчин, агаарын хөлөг шувуутай мөргөлдөх аюулаас сэргийлэх талаарх ерөнхий мэдлэг олгох, мөн аэродромын элементүүдийг таньж мэдэх, бэлэн байдлыг хангуулах, зөрчил дутагдлаас сэргийлэх

### **2. Суралцагчдад тавигдах шаардлага:**

Иргэний нисэхийн зориулалтаар үйл ажиллагаа явуулдаг нисэх буудлын аэродромын аюулгүй ажиллагаа, үзлэг шалгалт, ашиглалт хариуцсан ажилтан байх

### **3. Сургалтын агуулга:**

- Аэродромын эрх зүйн баримт бичгүүд
- Аэродромын төлөвлөлт
- Аэродромын үзлэг шалгалт, гадаргуун байдлыг үнэлэх тухай ойлголт
- Нисэх буудлын гал унтраах үйл ажиллагаа, онцгой байдлын төлөвлөгөө
- Аэродромын аюулгүй ажиллагаа
- Аэродромын орчмын шувуудын аюулаас урьдчилан сэргийлэх тухай
- Нисэхийн мэдээллийн тухай ойлголт
- Аэродромын цахилгаан хангамж, гэрэл суултын системийн тухай ойлголт
- Аэродромын холбоо, навигацийн тухай ойлголт
- Аэродромын ашиглалт
- Перроны зохицуулалт, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн
- Аэродромын хучилтын гадаргууг тоон утгаар үнэлэх ерөнхий ойлголт
- Аэродромын ажил гүйцэтгэх үеийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
- Дадлага ажил

### **4. Сургалтын орчин /танхим цахим/:**

Танхим

### **5. Сургалт зохион байгуулагдах хугацаа:**

53 цаг буюу 7 өдөр

### **6. Анги дүүргэлт:**

15-иас ихгүй суралцагч байна



## **Аэродромын инженер, техникийн ажилтны сургалт**

### **1. Сургалтын зорилго:**

Аэродромын тооцоо, хэмжилт судалгаа, үйл ажиллагааны мэдлэгийг бататгах, ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, хандлагыг дээшлүүлэх, олон улсын болон дотоодын эрх зүйн баримт бичгүүдийг танилцуулах

### **2. Суралцагчдад тавигдах шаардлага:**

Аэродром, авто зам, төмөр замын ашиглалтын болон барилгын инженер байх

### **3. Сургалтын агуулга:**

- Эрх зүйн баримт бичигтэй танилцаж, мөрдөж ажиллах
- Аэродромын төлөвлөлт хийх,
- Аэродромын барилга угсралтын ажлыг гүйцэтгэх
- Аэродромын ашиглалтын ажлыг гүйцэтгэх
- Аэродромын аюулгүй ажиллагааг хангах
- Аэродромын барилга угсралтын ажлыг гүйцэтгэх
- Аэродромын ашиглалтын ажлыг гүйцэтгэх
- Аэродромын аюулгүй ажиллагааг хангах

### **4. Сургалтын орчин /танхим цахим/:**

Танхим

### **5. Сургалт зохион байгуулагдах хугацаа:**

84 цаг буюу 11 өдөр

### **6. Анги дүүргэлт:**

10-20 суралцагч байна.



## **Аэродромын үзлэгийн ажилтны сургалт**

### **1. Сургалтын зорилго:**

Аэродромын маневрлах талбай перронд үзлэг хийх мэдлэг, ур чадвар хандлагыг дээшлүүлэх.

### **2. Суралцагчдад тавигдах шаардлага:**

Аэродромын үйл ажиллагааны сургалтад хамрагдаж гэрчилгээжсэн байх

### **3. Сургалтын агуулга:**

- Үзлэгийн үйл ажиллагаа
- Аэродромын аюулгүй ажиллагааг хангах

### **4. Сургалтын орчин /танхим цахим/:**

Танхим

### **5. Сургалт зохион байгуулагдах хугацаа:**

20 цаг буюу 3 өдөр

### **21 Анги дүүргэлт:**

15-20 суралцагч байна



## **Агаарын хөлгийн аэродромын орчимд шувуу, мал амьтантай мөргөлдөх аюулаас урьдчилан сэргийлэх давтан сургалт**

### **1. Сургалтын зорилго:**

Агаарын хөлгийг шувуутай мөргөлдөх аюулаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд оролцох нисэх буудлын ажилтанд шувуу, мал амьтны аюул, эрсдлийн тухай ойлголт өгөх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг иргэний нисэхийн ОУ-ын байгууллагын болон МУ-ын хууль, дүрэм журмын хүрээнд хэрэгжүүлэх сургалт, дадлагад хамруулж, мэдлэг ур чадвар олгох.

### **2. Суралцагчдад тавигдах шаардлага:**

Орнитологич инженер, орнитологич техникч, аэродромын ажилтан-шувуу үргээгч, аэродромын үзлэг, аюулгүй ажиллагаа хариуцсан инженер техникийн ажилтан, эсвэл шувууны хяналт, менежментийн үйл ажиллагаанд оролцдог ажилтан байх.

### **3. Сургалтын агуулга:**

- Агаарын хөлөг шувуутай мөргөлдөх аюулын тухай ерөнхий ойлголт
- Эрх зүйн баримт бичиг дүрэм журмууд
- Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй

### **4. Сургалтын орчин /танхим цахим/:**

Цахим/ танхим

### **5. Сургалт зохион байгуулагдах хугацаа:**

24 цаг буюу 5 өдөр

### **6. Анги дүүргэлт:**

20-иос ихгүй суралцагч байна.



## **Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн 14 цагийн сургалт**

### **7. Сургалтын зорилго:**

ИНЕГ болон түүний харьяа алба салбарын нийт ажилчдад аюулгүй ажиллах, ажлын байрны сөрөг хүчин зүйлсээс эрүүл мэндээ хамгаалахад зайлшгүй шаардлагатай ХАБЭА-н суурь болон хууль эрх зүйн ойлголтыг өгөхөд энэхүү сургалтын зорилго чиглэгдэнэ.

### **8. Суралцагчдад тавигдах шаардлага:**

Бүх ажилтан

### **9. Сургалтын агуулга:**

- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль эрх зүйг мөрдөж ажиллах
- Ажлын хувцас, хувийн хамгаалах хэрэгслийг зөв сонгох, хэрэглэх
- Ажлын байран дахь аюул эрсдэлийг таних илрүүлэх, мэдээлэх
- Гамшиг, ослын үед өөрийгөө болон бусдыг хамгаалах арга зүйг эзэмших

### **10. Сургалтын орчин /танхим цахим/:**

Цахим

### **11. Сургалт зохион байгуулагдах хугацаа:**

14 цаг буюу 2 өдөр

### **12. Анги дүүргэлт:**

24 суралцагч





## **Иргэний нисэхийн үйл ажиллагаатай танилцах сургалт**

### **1. Сургалтын зорилго:**

Иргэний нисэхийн салбарт шинээр ажилд орж буй ажилтнуудад Иргэний нисэхийн үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт, хууль эрх зүйн орчин, харьяа алба салбаруудын үйл ажиллагаа, онцлогийн талаар анхан шатны ойлголт өгч, харьяа үйлдвэрлэлийн албадуудтай танилцуулах

### **2. Суралцагчдад тавигдах шаардлага:**

Иргэний нисэхийн салбарын түр болон үндсэн ажилтан байна

### **3. Сургалтын агуулга:**

- ИНЕГ-ын үйл ажиллагаа
- ИНҮТ-ийн үйл ажиллагаа
- Эрх зүйн зохицуулалт, дүрэм журам
- ХАБЭА

### **4. Сургалтын орчин /танхим цахим/:**

Танхим болон цахим

### **5. Сургалт зохион байгуулагдах хугацаа:**

16 цаг буюу 2 өдөр

### **6. Анги дүүргэлт:**

15-20 суралцагч байна.



## **Ерөнхий англи хэлний яриа сонсголын ур чадвар дээшлүүлэх сургалт**

### **1. Сургалтын зорилго:**

Энэхүү сургалтаар суралцагчдын ерөнхий англи хэлний яриа, сонсголын ур чадварыг хөгжүүлэх өдөр тутмын болон албан харилцаанд хэрэглэгдэх харилцааны англи хэлийг багаар, хосоороо болон ганцаарчилсан хэлбэрээр асуудал дэвшүүлэх, хэлэлцүүлэг хийх, харилцан ярих зэрэг арга техникийг ашиглан дадлагажуулан сургахад оршино.

### **2. Суралцагчдад тавигдах шаардлага:**

Англи хэлний суурьтай анхан түвшний мэдлэгтэй байх

### **3. Сургалтын агуулга:**

- Англи хэлний сонсголын ур чадвар сайжруулах
- Англи хэлний ярианы ур чадвар сайжруулах
- Англи хэлний үг зүйн дүрэм үгсийн сан сайжруулах

### **4. Сургалтын орчин /танхим цахим/:**

Танхим, цахим

### **5. Сургалт зохион байгуулагдах хугацаа:**

40 цаг буюу 5 өдөр

### **6. Анги дүүргэлт:**

15-20 суралцагч байна.



## ***Иргэний нисэхийн хууль, дүрмийн ерөнхий сургалт***

### ***1. Сургалтын зорилго:***

ИН-ийн ажилтнуудад ИН-ийн холбогдолтой ОУ-ын гэрээ конвенц, хууль дүрэм, ОУ-ын стандарт, зөвлөмжүүд, ИН-ийн аюулгүй ажиллагааны үүрэг хариуцлага, осол зөрчлийн талаарх ерөнхий ойлголт, мэдлэгийг шинээр олгох, баталгаажуулах, сэргээх.

### ***2. Суралцагчдад тавигдах шаардлага:***

Иргэний нисэхийн салбарт ажилладаг байх,

### ***3. Сургалтын агуулга:***

- ОУ-ын ИН-ийн тухай Чикагогийн конвенцын агуулга бүтэц,
- ИН-ийн ОУ-ын стандарт зөвлөмж уялдаа холбоо,
- ИН-ийн тухай хууль, хуулийн бүтэц агуулга,
- ИНД-ийн бүтэц агуулга, зохицуулалт,
- ИН-ийн осол зөрчлийн тухай ойлголт мэдээлэх үүрэг хариуцлага,
- ИНД-12, ИН-ийн ажилтнуудын аюулгүй ажиллагааны талаар хүлээх үүрэг хариуцлага,

### ***4. Сургалтын орчин /танхим цахим/:***

Танхим болон цахим

### ***5. Сургалт зохион байгуулагдах хугацаа:***

8 цаг буюу 1 өдөр

### ***6. Анги дүүргэлт:***

20-иос ихгүй байна.



## **Иргэний нисэхийн аюулгүй ажиллагаа ба аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцооны сургалт**

### **1. Сургалтын зорилго:**

ИН-ийн салбарын ажилтнуудад аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоо, түүнийг үйл ажиллагаандаа хэрхэн үр ашигтайгаар нэвтрүүлэх талаар ерөнхий мэдлэг олгох.

### **2. Суралцагчдад тавигдах шаардлага:**

-

### **3. Сургалтын агуулга:**

- Суурь мэдлэгийг эзэмших
- ОУИНБ-ын шаардлага, стандартуудыг танилцуулах
- SMS-г хэрэгжүүлэх
- Аюулгүй ажиллагааны соёлын талаар мэдлэг олгох

### **4. Сургалтын орчин /танхим цахим/:**

Танхим болон цахим

### **5. Сургалт зохион байгуулагдах хугацаа:**

16 цаг буюу 2 өдөр

### **6. Анги дүүргэлт:**

15-20 суралцагч байна.



## **Заах арга зүйн сургалт**

### **1. Сургалтын зорилго:**

Нисэхийн сургалтын төвийн “ Үйл ажиллагааны заавар”-ын 2.7 дахь заалт “Ажилтан, албан хаагчдын мэдлэг, ур чадвар, дадлыг бататгах, хөгжүүлэх”, 3.2 дахь заалт “НСТ-д зохион байгуулагдах сургалт, дадлага, тэдгээрийн төрлүүд”-ийн заалтын дагуу суралцагчдыг хамруулж мэдлэг ур чадвар олгох.

### **2. Суралцагчдад тавигдах шаардлага:**

- НСТ-ийн ҮАЕЗ-ын 2.6.1 дэх заалт “Иргэний нисэхийн тусгай мэргэжлийн багш болон шалгагч нарт тавигдах шаардлага”, “Түгээмэл мэргэжлийн багш болон шалгагч нарт тавигдах шаардлага”
- НСТ-ийн ҮАЕЗ-ын 2.8.19 дэх заалт “Сонгон шалгаруулалтаар 80%-иас дээш оноотой буюу хангалттай үнэлгээ авсан этгээдтэй НСТ нь “Цагаар багшлуулах гэрээ”-г байгуулж хамтран ажиллана.

### **3. Сургалтын агуулга:**

- Заах арга зүйн талаарх ерөнхий ойлголт, сургах үйл ажиллагааны зарчмууд
- Сургах үйл ажиллагааны бүтээлч сэтгэлгээний түвшин, сургалтын аргыг сонгох
- Сургалтын арга түүний ангилал
- Багшийн хичээлийн бэлтгэл, хөнгжүүлэх сургалтын аргууд
- Сургалтын арга барил
- Дадлага

### **4. Сургалтын орчин /танхим цахим/:**

Танхим

### **5. Сургалт зохион байгуулагдах хугацаа:**

8 цаг буюу 1 өдөр

### **6. Анги дүүргэлт:**

20-иос дээшгүй суралцагч байна.



## **Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулах арга зүйн сургалт**

### **1. Сургалтын зорилго:**

Чадамжид суурилсан сургалтын тухай ойлголт, НСТЖ-09 “Сургалтын хөтөлбөр боловсруулах” журамтай танилцаж, чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр хэрхэн боловсруулах арга зүйг эзэмшиж, бие даан сургалтын хөтөлбөр боловсруулахад оршино.

### **2. Суралцагчдад тавигдах шаардлага:**

Тухайн хичээл заах мэргэжлийн чиглэлээрээ мэргэшсэн байна.

### **3. Сургалтын агуулга:**

- Нэршил, нэр томъёоны ойлголт болон журмуудтай танилцах
- Сургалтын хөтөлбөрт дүн шинжилгээ хийх, хөтөлбөр боловсруулах

### **4. Сургалтын орчин /танхим цахим/:**

Танхим болон цахим

### **5. Сургалт зохион байгуулагдах хугацаа:**

16 цаг буюу 2 өдөр

### **6. Анги дүүргэлт:**

15-20 суралцагч байна.